МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/04 Алтай хот

Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2.Бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу сум бүр дэд төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг жил бүрийн нэгдүгээр сард багтаан аймгийн Онцгой комиссын хурлаар тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, явц үр дүнг улирал тутам аймгийн онцгой комиссын хурлаар танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3А-4 doc

0201000020

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 11-ны өдрийн А/04 дугаар
захирамжийн хавсралт

# МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТИЙН ҮЕД МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|
| Аймгийн Мал эмнэлгийн газрын хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ | | | |
| 1 | Хорио цээрийн дэглэм тогтоох, цуцлах үндэслэлийг гаргах | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 2 | Засаг даргын захирамжаар тогтоосон хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх, өвчний тархалт, хүрээ, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хил залгаа аймаг, сумын малын эмч нарт мэдэгдэх, харилцан мэдээлэл солилцох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 3 | Гоц халдварт өвчний хорио цээр, хязгаарлалтын бүсэд ариутгал, халдваргүйжүүлэлтийг шуурхай зохион байгуулах | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 4 | Малд нэг бүрчлэн эмнэл зүйн үзлэг хийж өвчтэй малыг хяналтад авч тусгаарлах, шинж тэмдгийн эмчилгээ хийх | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 5 | Эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй малд мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж, зааврын дагуу урьдчилан сэргийлэх вакцин тарих, гүйцэтгэлийг тайлагнах | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 6 | Өвчин гарсан айл өрхөд малын шилжилт, хөдөлгөөн хийхгүй, түүхий эд (мах, сүү, ноос, ноолуур, арьс, ширгэх мэт) бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ олгохгүй, хяналт тавих; | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 7 | Халдваргүйтгэлийн цэгээр дамжин өнгөрөх хүн, тээврийн хэрэгслийг стандартын дагуу халдваргүйтгэх | Тухай бүр | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |
| 8 | Өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг халдваргүйжүүлэлт хийж, мэргэжлийн ангитай хамтран устгал хийх | Тухай бүр | Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар Онцгой байдлын газар |
| 9 | Мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийн талаарх сурталчилгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах | 7 хоног бүрийн даваа баасан гарагт | Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Өвчний нөхцөл байдлын мэдээллийг сумдаас нэгтгэн авч, Мал эмнэлгийн ерөнхий газар болон холбогдох байгууллагуудад нэгдсэн нэг мэдээллээр хангах | Өдөр бүр 16:30 цагт | Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг, |
| | Нутгийн захиргааны байгууллагын (Засаг дарга) хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ | | |
| 1 | Орон нутгийн мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмчийн дүгнэлтийг үндэслэн хорио цээрийн дэглэм тогтоох, цуцлах тухай шийдвэр гаргах; | Тухай бүр | Сумдын Засаг дарга |
| 2 | Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсд "Шуурхай бүлэг" болон мал эмнэлгийн нарийн мэргэжлийн, хяналтын, устгалын, шалган нэвтрүүлэх, зорчигч тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэх, хэв журам сахиулах зэрэг мэргэжлийн анги томилон ажиллуулах | Тухай бүр | Сумдын Засаг дарга, Онцгой байдлын газар |
| 3 | Аймгийн Онцгой комиссын хурлаар үүссэн нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардлагатай хөрөнгө, зардлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах | Тухай бүр | Сумдын Засаг дарга, Онцгой байдлын газар |
| 4 | Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг дайчлах; | Тухай бүр | Сумдын Засаг дарга |
| 5 | Олон нийтийг хамарсан арга хэмжээ (хурал, цуглаан, сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа, спорт, урлагийн тоглолт, баяр наадам, уул овоо тахих, хурдан морины уралдаан, бөхийн барилдаан гэх мэт) зохион байгуулахыг хориглох, хугацааг өөрчлөх; | Тухай бүр | Сумдын Засаг дарга |
| 6 | Гамшгаас хамгаалах албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлагаар хангах; | Тухай бүр | Сумдын Засаг дарга, Онцгой байдлын газар |
| 7 | Голомтын бүсэд хүнс, өргөн хэрэглээний болон бусад шаардлагатай барааны хангалтыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх | Тухай бүр | Сумдын Засаг дарга, Онцгой байдлын газар |
| | Аймгийн Онцгой байдлын газрын хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ | | |
| 1 | Аймаг, сум, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний "Олон улсын хөл хориот, гоц халдварт өвчний үед ажиллах" хэсэгт тодотгол хийх; | Тухай бүр | Онцгой байдлын газар Сум, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги |
| 2 | Аймаг, сумын Онцгойкомисс болон Засаг даргын шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх; | Тухай бүр | Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар |
| 3 | Хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүлийг Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулах; | Тухай бүр | Онцгой байдлын газар |
| 4 | Хорио цээрийн бүсэд тогтоосон горимыг дагаж мөрдүүлэх, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахих; | Тухай бүр | Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар |
| 5 | Халдварын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүнийг тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэгслээр хангах, хамгаалах хувцас хэрэгсэл өмсгөлийг тогтоосон дарааллын дагуу тайлж, ариутгахад хяналт тавих; | Тухай бүр | Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн анги |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Онцгой байдлын ерөнхий газар, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газарт нэгдсэн тайлан мэдээг өдөр бүр өгч байх; | Өдөр бүрийн 19:00 цагт | Онцгой байдлын газар, Аймгийн нэгдсэн шуурхай штаб |
| 7 | Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд ажиллаж байгаа шуурхай бүлэг, мэргэжлийн анги, эргүүл, хяналтын цэг болон удирдлагын байрыг холбоогоор хангах; | Тухай бүр | Онцгой байдлын газар |
| 8 | Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хяналт тавих | Тухай бүр | Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар |
| | Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ | | |
| 1 | Засаг даргын захирамжийн биелэлт, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангаагүй албан тушаалтан, иргэнд хариуцлага тооцох; | Тухай бүр | Мэргэжлийн хяналтын газар<br>Цагдаагийн газар |
| 2 | Хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтад хяналт тавих | Өдөр бүр | Мэргэжлийн хяналтын газар<br>Мал эмнэлгийн газар |
| 3 | Халдварт өвчний голомт, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд зорчих хөдөлгөөний замын зураглал гаргаж хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, зохицуулах, хяналт тавих | Тухай бүр | Цагдаагийн газар<br>Мэргэжлийн хяналтын газар |
| 4 | Тухайн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа улсын чанартай авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналтад авч, нэвтрэх зөвшөөрөл, халдваргүйжүүлэлт хийлгэсэн тухай баримтыг үндэслэн нэвтрүүлэх | Тухай бүр | Цагдаагийн газар<br>Мэргэжлийн хяналтын газар |
| 5 | Халдваргүйтгэл, хяналтын цэгээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийг бүртгэх, дэг журам сахиулах | Тухай бүр | Цагдаагийн газар |
| 6 | Өвчний гарал үүсэл, голомт нэмэгдэх шалтгаан нөхцлийг олж тогтоох | Тухай бүр | Цагдаагийн газар<br>Тагнуулын газар |
| 7 | Нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах; | Тухай бүр | Цагдаагийн газар |
| | Аймгийн Эрүүл мэндийн газрын хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ | | |
| 1 | Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан томилогдон ажиллаж байгаа гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн албан хаагчдын болон голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх; | Тухай бүр | Сумын эрүүл мэндийн төв |
| 2 | Шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлэх, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах; | Тухай бүр | Сумын эрүүл мэндийн төв |
| | Иргэн, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх арга хэмжээ | | |
| 1 | Малын өвчинтэй тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, холбогдох хууль тогтоомжийг биелүүлэх | Тухай бүр | Малчид, мал бүхий иргэн, ААН |
| 2 | Малд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн үйлчилгээний нэгж, баг, хорооны удирдлагад 12 цагийн дотор мэдэгдэх | Тухай бүр | Малчид, мал бүхий иргэн, ААН |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Малын эмчийн зааврын дагуу өвчтэй малын бууц, баас, тэжээлийн үлдэгдлийг шатааж устгах, өвчтэй малын арчилгаа, маллагаа, тэжээлийн нөхцөлийг сайжруулж өдөр тутмын арчилгаа, маллагааг гардан гүйцэтгэх | Тухай бүр | Малчид, мал бүхий иргэн, ААН |
| 4 | Малын хашаа, хороо, байрны ариун цэвэр, эрүүл ахуйн болон технологийн дэглэмийг сахих; | Тухай бүр | Малчид, мал бүхий иргэн, ААН |

__oOo__